



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/29

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг шилжүүлэх  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаал “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Боржигин овогт Очирын Бямбасүрэн /ЕЮ61093002/ нь Шивээговь сумын 2-р баг, Нэрт-2 гудамжны 5-н тоотод байршилтай “Гэр, орон сууцны хашаа”-ны зориулалттай 798м2 газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул иргэн Боржигон овогт Сандагийн Байгалмаа /ЗБ73020501/-д Шивээговь сумын 2-р баг, Нэрт-2 гудамжны 5-н тоотод байршилтай, “Гэр, орон сууцны хашаа”-ны зориулалттай, 798м2 газрыг шилжүүлэн 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн /С.Байгалмаа/-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн Сандагийн Байгалмаатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/177 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА *П.ГАНЧИМЭГ* П.ГАНЧИМЭГ

